



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 18 одер

Дугаар 11544

Чойбалсан

Г Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л", 39 дүгээр зүйлийн 39.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178, 181 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 06 дугаар албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 57 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 181 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/540 дүгээр захирамжийн 1 дэх заалтын "2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06.00 цаг" гэснийг "2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06.00 цаг" болгон өөрчилж коронавируст халдварт /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсүгэй.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймаг, сумдын Онцгой комисс, Шуурхай штабууд, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга /Ч.Ганбат/-д үүрэг болгосугай.

3. Эрээнцав төмөр замын боомтоор улсын хил нэвтрэх ачааны галт тэрэгний машинист, хөлөг ажилчид /агент/-ыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс бүрэн тусгаарлаж үүрэг гүйцэтгүүлэн, халдварт хамгааллын дэглэм, холбогдох журмыг чанд мөрдүүлэн, шаардлагатай бол нэмэлт дүрэм, журам, удирдамжийг шуурхай батлуулан ажиллахыг Улаанбаатар төмөр замын Баянтумэн тасгийн дарга /П.Түвшинжаргал/, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Мөнхтуяа/, Гаалийн газрын дарга / Б.Гэрэлт-Од, Хилийн 0275 дугаар ангийн захирагч /дэд хурандаа О.Баттулга/, Чулуунхороот сумын Засаг дарга /З.Гэрэлт-Од/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д

М.БАДАМСҮРЭН

/My computer D/ Zakhiramj

0101 1653